



ENSADA ТРАКТРОН ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,

Савдугийн гудамж 24, М Plaza, 17 давхар

Утас: 70109833, Факс: 70119833, www.ensada.mn

4019.02.23 № 39

Өвс тэжээл импортлон нийлүүлэх гэрээний тухай

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас хэрэгжүүлж буй “Өвс, тэжээл импортлох, дотооддоо үйлдвэрлэх, малчид, фермерүүдэд нийлүүлэх” ӨТСШ/17/11/01 дугаартай төсөл сонгон шалгаруулалтад манай компани шалгарч ХХААХҮЯ болон Мал хамгаалах сантай холбогдох гэрээнүүдийг байгуулан эдгээр гэрээтэй холбоотой үүргээ хариуцан ажиллаж байна.

№171122/04-210 тоот гэрээний дагуу Улаанбаатарт нийлүүлэгдэх уурагт тэжээлийг үйлдвэрийн түүхий эдийн нөөц дээрээ тулгуурлан тэжээлийн үйлдвэртээ тогтмол үйлдвэрлэж байна. Өнөөдрийн байдлаар 10 тонн уурагт тэжээлийг малчдад борлуулж, Улаанбаатар дахь агуулахад дахин 10 тонн уурагт тэжээл, Хэнтий аймаг дахь агуулахад 30 тонн уурагт тэжээл нийлүүлж хадгалагдаж байгаа ба үйлдвэрлэлийг хэвийн үргэлжлүүлбэл агуулахын нөөц хангалттай ч нэмэгдэх хандлагатай байна. ОХУ-н түүхий эд нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу эхний 1 вагон овьёос 2 сарын 23-ны өдөр ирж, 2 дахь вагон 2 сарын 28-ны өдөр Толгойт өртөөнд ирэх ба гэрээ хэвийн үргэлжилбэл дараачийн цуваа үргэлжлэн орж байгаа боломжтой байна.

Гэвч зах зээлийн хандлага болон малчид энгийн хивэг худалдаж авах сонирхол их байгаа нь гэрээний дагуу манай компанийн нийлүүлэх ёстой уурагт тэжээлийн эрэлтийг хангах агуулахын нөөцийг нэмэгдүүлж байна. Зах зээлийн эрэлтийн өсөлтийг даган бид үйлдвэрлэлт болон нийлүүлэлтийн хурдыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байгаа ч хэрэв та бидний зүгээс гэрээг цуцлах шаардлагатай хэмээн үзэж байвал бид улсад хүндрэл учруулах сонирхолгүй байгаа учир цаашдын хамтын ажиллагаагаа хүндэтгэн бидний хооронд

байгуулсан гэрээнүүдийг цуцалж, гэрээний хуваарийн дагуу төлбөрийг эргүүлэн төлөхөд бидний зүгээс татгалзах зүйлгүй болохыг хүндэтгэлтэйгээр илэрхийлье.

Нөхцөл байдлаас үл хамааран манай компани дотоод нөөц бололцоогоо ашиглан 2018 оны 04 сарын 30-ны өдрийг хүртэл хүчит тэжээл үйлдвэрлэн Улаанбаатар хот. БГД. Эрчим хүчний гудамж дахь тэжээл борлуулах агуулах, Сонсголонгийн зам дээрх жижиглэнгээр борлуулах төв, Багануур дүүрэг болон Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Жаргалтхаан сумууд болон Чингис хотод зах зээлийн эрэлтэд тулгуурлан тогтмол нийлүүлсээр байх ба энэ нь ХХААХҮЯ-ны хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийг дэмжсэн ахам болно гэж найдаж байна.

Хүндэтгэсэн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/Д.БАТДОРЖ/

МАЛ ХАМГААЛАХ САН

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16А, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-11) 45 32 33

2018. 03. 06 № 94
танай 2018. 03. 23 -ны № 39 -Т

Албан бичгийн хариу

Танай компаниас 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 39 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг хүлээн авч танилцлаа.

Тус сангийн зүгээс Иргэний хуулийн 204 дүгээр зүйлийн 204.2 дахь хэсэгт “Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээнээс татгалзах хугацааг татгалзах санал гаргаагүй тал нь тогтооно” гэж заасны дагуу “ОХУ-аас малын тэжээл импортлон оруулж ирэх аж ахуйн нэгжтэй байгуулах” 2017/Ү/22 дугаартай зээлийн гэрээг 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөр тасалбар болгон цуцалж байна.

Иймд 2017/Ү/22 дугаартай зээлийн гэрээгээр зээлсэн 730,000,000 (долоон зуун гучин сая) төгрөгийн зарцуулалтын тооцоог нэн даруй нийлж, Мал хамгаалах сангийн Төрийн сан дахь 100900019044 тоот дансанд буцаан төлнө үү.

ЗАХИРАЛ



Т.ЦЭДЭНДАМБАА

008011 83